



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/96.

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын газрын
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан гурван аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан дөрвөн аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Ээвж Номт ХХК-ийн "Бамбино" зочид буудлын 13/58, БХХ ХХК-ийн "Санрайс" зочид буудлын 13/27, Бөх Буян Арвижих ХХК-ийн "Марал" дэн буудлын 14/72, Нью Жаско ХХК-ийн "Марс" зочид буудлын 15/093, Эрмон Билэг ХХК-ийн "Эрмон Билэг" дэн буудлын 13/254, Далай-Үүр ХХК-ийн "Американ" зочид буудлын 13/267 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

5. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 11 сарын 07 өдрийн
А/96 дугаар - тушаалын нэгдүгээр
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ


2016.11.07

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	БХХ ХХК	2114399	Санрайс	Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, 18-р байр
2	Ээвж Номт ХХК	5043336	ДН	Баянзүрх дүүрэг, 2-р хороо, Их Дарь эхийн 1/5в
3	Далай-Үүр ХХК	5627648	Американ	Баянзүрх дүүрэг, 6-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 33а

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 11 сарын 07 өдрийн
А/95 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2016.11.07

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Адвейнтур Райдер ХХК	5654297	Адвейнтур Райдер	Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, 18-р байр
2	Иргэн Ө.Жанил	ШД71121713	Марал	Хан-Уул дүүрэг, 6-р хороо, Нүхтийн 30-578 а
3	Нью Жаско ХХК	5168848	Марс	Баянгол дүүрэг, 17-р хороо, Жалханз Хутагт Дамдинбазарын гудамж 67/1
4	Эрмон Билэг ХХК	2585022	Эрмон Билэг	Баянгол дүүрэг, 17-р хороо, 4-р хороолол 39

-ooOoo-